

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН 2017 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.09.25

Улаанбаатар хот

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, ажлын чиглэлд тусгагдсан ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн Б/34 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагаас 2017 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох, баримт бичгийн жагсаалтын хүрээнд тус цагдаагийн газар нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогт тохируулан 2 зүйл 31 заалт заалттай төлөвлөгөө боловсруулж, Эрүүгийн цагдаагийн тасаг- 2, Мөрдөн байцаах тасаг-3, Нийтийн хэв журам хамгаалах тасаг-11, Захиргааны удирдлагын тасаг-15 ажлын төлөвлөгөөг тасгуудад хувиарлан тогтсон хугацаанд биелэлт үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын 1 дүгээр зэрэглэлд шилжүүлж ажиллуулах тухай” А/146 мөн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “ Цагдаагийн түр хүрээ байгуулах тухай” А/147 дугаар тушаал, Нийтийн хэв журам хамгаалах газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/22 дугаар тушаалыг үндэслэн тус цагдаагийн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 дахь шатны санал хураалтын хамгаалалт болон Тулгар төрийн 2226, Их Монгол улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеийн олон нийтийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бие бүрэлдэхүүнийг 2017 оны 07 сарын 06-ны өдрийн 09:00 цагаас 2017 оны 07 сарын 14-ны өдрийн 09:00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын 1 дүгээр зэрэгт шилжүүлж жижүүрийн шуурхай удирдлага, албадан эрүүлжүүлэх байрны хуваарь, эргүүл, жижүүрийн томилгоо, суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хуваарийг баталж газрын бие бүрэлдэхүүнд дээрх тушаал, үүргийг танилцуулж тус цагдаагийн газрын даргаас алба хаагчдад үүрэг чиглэл өгсөн.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны төлөвлөгөөт шалгалтын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Ч.Болдбаатараас 4/1039 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагчийн өдөр тутмын гүйцэтгэж байгаа үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж шалган зааварчлах, алба хаагчдын зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Төмөр зам дахь цагдаагийн газрын дотоод хяналт, шалгалтын чиглэлээр 2017 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг 12 заалттайгаар шинэчилэн боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна

Цагдаагийн ерөнхий газрын даргын хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэх 2 дугаар улирлын төлөвлөгөөний хүрээнд цагдаагийн газраас хэрэгжүүлэх ажлын тайланг гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэг дэх үе шатны төлөвлөгөөний хүрээнд Төмөр зам дахь цагдаагийн газраас 2017 онд хэрэгжүүлэх ажлын 46 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлж байна.Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр аюултай

бүсийн дэглэмийг сахиулан ажиллаж байгаа эргүүл, жижүүр, өртөө, зөрлөгт суурин ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч бүрийн ажлын байрны нөхцөл, албан тушаалын байр, холбоо мэдээллийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, шатах тослох материал, алслагдсан сум орон нутагт ажилласан хугацааны нэмэгдэлийг тухай бүр олгуулан эдийн засгийн баталгааг хангуулахад гол ажлаа чиглүүлсэний дүнд, Сэлэнгэ аймгийн Мандал өртөөний хэсгийн байцаагч цагдаа нарыг 24 айлын төвийн шугамд холбогдсон 2 өрөө орон сууцаар хангасан. Айраг, Баруун хараа өртөөнд албан тушаалын байрыг шийдүүлэхээр төмөр замын удирдлагуудад хандсан.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаалын талаар:

2017 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр тус цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 31 заалттайгаар баталсан ба 2017 оны 03 дугаар улиралд цагдаагийн газрын даргын зөвлөл 7 удаа хуралдсан байх ба нийт 25 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

Хүний нөөцийн асуудал 13 буюу 52 хувь, санхүү, төсвийн асуудал 1 буюу 4 хувь, цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал 1 буюу 4 хувь, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал 10 буюу 40 хувийг тус тус эзэлж байна.

Тус цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 9, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 42 батлагдан гарсан байна.

1.3. Хүний нөөцийн талаар:

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”, мөн зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”, Цагдаагийн байгууллагад анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам код 902-т заасны дагуу тус цагдаагийн газарт ажиллах хүсэлт гаргасан 25 иргэнийг судлан журамд заасан шаардлага хангаж буй 20 иргэнийг мэргэшлийн шалгалтанд оролцуулахаар материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлснээс 6 иргэнийг ахлагч бүрэлдэхүүнд оруулан цагдаагийн дэд ахлагч цол олгов.

Нийслэлийн цагдаагийн газраас судлагдан нөөцөд авагдсан 15 иргэний материалыг судлан 9 иргэнийг ахлагч бүрэлдэхүүнд оруулан, цагдаагийн дэд ахлагч цол олгов.

Тус цагдаагийн газарт шилжин ажиллах хүсэлт гаргасан 7 алба хаагчийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах журам код 908-т заасны дагуу судлан 2 алба хаагчийг шилжүүлэн томилуулав. 1 алба хаагч хүүхэд төрүүлэн хүүхдээ 3 нас хүртэл нь асрах хүсэлт гаргасан тул Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу хүүхэд асрах чөлөөг олгуулав.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасан цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 2 алба хаагчийн ажилласан жилийн лавлагааг гаргуулан цэргийн байнгын тэтгэвэр тогтоон 36 сарын цалин хөлстэй тэнцэх нэг удаагийн тэтгэмж олгуулах саналтай материалыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэв.

Тус цагдаагийн газрын удирдлагууд ажлын цагаар иргэн аж ахуйн нэгж алба тушаалтангаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрийн танилцуулан хариуг хүргүүлж ирсэн. 2017 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагын удирдлагад хандан өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.

1.4. Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ:

Тус газраас 2017 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагын үйл ажиллагаандаа дараах шинэлэг ажлуудыг нэвтрүүлж ажиллаж байна. Үүнд:

➤ Алба хаагчдын сэтгэл зүйн хувийн хэрэгт сэтгэл зүйн болон сэтгэл ханамжийн бусад тест, тодорхойлолт материалуудыг хавсарган сэтгэл зүйн мэдээллийн нэгдсэн санг баяжуулж ажиллаж байна.

➤ Төмөр замаар зорчиж байгаа зорчигчдын мэдээллийн санг ашиглах программыг Улаанбаатар төмөр зам ХНН-ийн Статистик бүртгэл, мэдээллийн хэлтсээс онлайн хэлбэрээр авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

➤ Харилцааны соёлоо дээшлүүлж, сахилга ёс зүйн зөрчилгүй хамт олон болцгооё” аяныг Аяныг 2 үе шаттай зохион байгуулахаар удирдамж, календарьчилсан төлөвлөгөөг батлуулсан бөгөөд 2 дугаар үе шатыг эхлүүлээд байна.

➤ Сахилгын зөвлөгөөнд оролцсон алба хаагчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулж, асуудал хөндсөн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийх хэлбэрээр зохион байгуулсан нь алба хаагч бүрийн оролцоо, идэвхийг сайжруулсан. Мөн сүүлийн 10 жил сахилга ёс зүйн зөрчилгүй хамт олноо манлайлж ажилласан алба хаагчдад “Батламж” олгосон нь алба хаагчдын талархлыг хүлээж цаашид ажиллах идэвх, урам зоригийг нэмэгдүүлсэн.

➤ Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлаас буухдаа хувцасны өрөөнд шүүгээнд дүрэмт хувцас тусгай хэрэгслээ үлдээн энгийн хувцас өмсөж хэвшсэн нь аюулгүй байдлыг хангах нэг томоохон ажил болсон байна.

➤ Газрын хэмжээнд хоногийн хугацаанд эргүүл, жижүүр ээлжид 37-40 алба хаагч ажилладаг бөгөөд үүрэг гүйцэтгэхийн өмнө эрүүлжүүлэх байрны эмчид артерийн даралт, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулан ажил үүргээ гүйцэтгэдэг нь алба хаагчийн эрүүл мэндийн байдал, үүрэг гүйцэтгэх чадвартай эсэх, эрүүл цагтаа ирсэн байдалд дүгнэлт хийж, хяналт тавихад дөхөм болдог.

➤ Алба хаагчдыг албаны сургалт бичиж тэмдэглэх нэг ижил дэвтрээр ханган сургагч ахлагч хичээл тэмдэглэлтэнд анхаарч ажилладаг болсон зэрэг шинэлэг ажлуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2.1 Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Тус газрын эрүүгийн цагдаагийн тасаг нь “Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажлыг эрчимжүүлэх, илрүүлэлтэд ахиц гаргах” гэсэн зорилтын хүрээнд урьд онд болон энэ онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй эрүүгийн тоот хэргүүдийг илрүүлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газар болон Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газрын даргаас хэрэгжүүлэхээр даалгасан албан даалгаваруудыг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор УБТЗ-аар тээвэрлэгдэж буй нийт ачаа эргэлт болон химийн хортой болон аюултай ачаа, түүнчлэн тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэнд зохих түвшинд хяналт тогтоож давхардсан тоогоор 15 байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн ачаа вагонд үзлэг шалгалтуудыг ГЕГ, УМХГ-ын хяналтын байцаагч нар болон төмөр замын Тээвэр зохион байгуулалтын албаны ажилтнуудтай хамтарч зохион байгуулан үр дүнг тооцон ажилласан. Энэ чиглэлд ГА-ын туслах хүчийг оновчтой зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагч бүрт тодорхой албан даалгавруудыг хариуцуулан, түүнд чиглүүлэн ажиллуулж, даалгаврын хэрэгжилт, нөхцөл байдлын талаар дээд шатны байгууллагуудад тогтоосон хугацаанд нь бичгээр танилцуулж байна.

ЦЕГ-ын даргын 2009.06.09-ний №02 албан даалгавар “Ой хээрийн түймрийн хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”, ЦЕГ-ын тэргүүн дэд даргын 2009.10.08-ны №01 албан даалгавар “Хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэх, худалдах явдалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай”, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоол /19/ “Сэтгэцийн эрүүл мэнд” Үндэсний 2 дахь хөтөлбөр /төлөвлөгөөний 1.6 заалтын биелэлт/, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 277 дугаар тогтоол “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай журмын /2.6 заалт/ биелэлт, ЦЕГ-ын даргын 2007 оны 01 дүгээр албан даалгавар “Түүх соёлын дурсгалт зүйлс сүйтгэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, ЭЦГ-ын даргын 2007 оны 02 дугаар албан даалгавар “Хүн худалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох илрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, ЦЕГ-ын даргын 2007 оны 03 дугаар албан даалгавар “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүн барьцаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай”, ЭЦГ-ын даргын 2008 оны 02 дугаар албан даалгавар “Мансууруулах, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай”, ЭЦГ-ын даргын 2009 оны 03 дугаар албан даалгавар “Зохион байгуулалттай бүлэг, бөөгнөрөл, гэмт бүлэглэлтэй тэмцэх ажлыг сайжруулах тухай”, ЭЦГ-ын даргын 2009 оны 04 дүгээр албан даалгавар “Монгол улсад оршин суугаа гадаадын иргэдийн зүгээс үйлдэж буй гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх тухай”, ЭЦГ-ын даргын 2011.12.22-ны 588-р тушаал албан даалгавар “Интернет, цахим тоглоомын үйлчилгээг дагалдан үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, ЭЦГ-ын даргын 597 тоот тушаал, албан даалгавруудын биелэлтүүдийг гаргаж Эрүүгийн цагдаагийн газрын чиглэлийн хэлтсүүдэд улирал, хагас жилээр хугацаанд нь гарган хүргүүлсэн.

Эрүүгийн, эдийн засгийн, хэсгийн төлөөлөгч нар бусад албанаас зөрчлийн талаар мэдээлсэн нийт 45 илтгэх хуудас хүлээн авч, хуулийн хугацаа хэтрүүлэлгүй шалгаж хариу өгсөн ба хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанаас хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн даалгавар нийт 10-ыг хүлээн авч шалгасан байна.

Төлөөлөгч нарын гэмт хэрэг илрүүлэлтийн талаар:

Төмөр зам дахь цагдаагийн газрын эрүү, эдийн засгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч нар 2017 оны 3-р улиралд 64 холбогдогчтой 878 сая 210 мянган төгрөгний хохиролтой 56 гэмт хэрэг илрүүлэн ажилласан байна.

Эрэн сурвалжлах ажлын талаар:

Тус цагдаагийн газраас 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын “ASAP” санд тус газраас оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 4, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 1, эд зүйлс 12, нийт 18 эрэн сурвалжлах хүн, цогцос, эд зүйлсийн мэдээлэл бүртгэгдэж зарлагдсан ба үүнээс оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 1, эд зүйлс 9, нийт 12 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

1. Тус газраас эрүүгийн тоот хэрэгт гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000016 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 33 настай Цэрэннамжил овогтой Мэндсайхан РД:/ИЦ83022315/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2. Тус газраас эрүүгийн тоот хэрэгт оргодолоор “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Гончиг овогтой Даваасүрэн РД:/ Н362022675 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3. Тус газраас эрүүгийн тоот хэрэгт хэн болох нь тогтоогдоогүй цогцос “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001317000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Дорлиг овогтой Доржсүрэн РД:/ ОР76091919 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000019 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

5. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000018 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

6. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000008 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

7. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000010 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

8. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000007 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

9. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000013 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

10. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

11. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000009 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

12. Тус газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000012 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтсээс Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах “ASAP сан”-д бүртгэгдэж зарласан оргодол 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 4, гэрээсээ гараад сураггүй алга болсон 3, шүүхээс оргон зайлсан 4 хүнийг олж тогтоон нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч ажилласан байна.Үүнд:

1. СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс эрүүгийн 201526012399 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541205516000137 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Нармандах овогтой Ганжигүүр РД:/ М089100717 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2. БГД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201626022780 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541205217000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 35 настай Баасанжав овогтой Батгэрэл РД:/ ЧИ82011975 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3. Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас “Эрэн сурвалжлах АСАП” санд 541104516000068 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 17 настай Жаргалсайхан овогтой Наранцэцэг РД:/ ИИ00231503 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4. СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541105516000111 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 40 настай Даваадулам овогтой Тэгшбаяр РД:/ Ч377010930/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

5. СБД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201625025404 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540105817000533 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 35 настай Молтов овогтой Жаргалсайхан РД:/ Х370091211 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

6. ХУД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 542306017000003 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 39 настай Чимэдгочоо овогтой Зундуй-Ёндон РД:/ ЧИ78051875 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

7. ЧД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201525030196 тоот хрээгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541206215000051 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 17 настай Содномцэрэн овогтой Баярмаа РД:/ УУ74110900 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

8. СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541105516000107 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 43 настай Содномцэрэн овогтой Баярмаа РД:/ УУ74110900 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

9. Багахангай дүүргийн цагдаагийн хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540002817000003 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 38 настай Тувайнжав овогтой Намуунзул РД:/ ХМ79072510 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

10. БГД-ын цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541205117000070 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Цэрмаа овогтой Гэрэлтуяа РД:/ ХМ79072510 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

11. Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540004517000073 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 18 настай Батзориг овогтой Дөлгөөн РД:/ М304252011 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

12. Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540004517000074 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 17 настай Бат-Эрдэнэ овогтой Эрдэнэцогт РД:/ М303231131 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

13. БЗД-ын цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 20150608408 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 541105416000315 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Баттөмөр овогтой Энхзаяа РД:/ Ч381090885 /-г тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.

2.2 Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Тус цагдаагийн газрын мөрдөн байцаах тасаг нь орон тоогоор тасгийн дарга 1, ахлах мөрдөгч 2, жинхэнэ мөрдөгч 3, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ж.Гэрэлт-Од нь 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл Мөрдөн байцаах албаны Залилах гэмт хэрэг мөрдөх хэлтэст байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан.

Хяналтын прокуророос хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд тавих хяналт, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох оролцоог дээшлүүлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Тээврийн прокурорын газартай хамтарсан зөвлөлгөөнийг 1 удаа зохион байгуулж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар болон өртөө зангилаадад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарыг бүрэн хамруулсан.

Мөрдөн байцаалтын ажиллагааны талаар:

2017 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 8 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 5 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, одоогийн байдлаар гомдол мэдээллийн үлдэгдэлгүй байна.

Нийт 12 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаас 1 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2 хэргийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 1.610.000 төгрөгийн хохирлоос 1,610,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, нийт хохирлыг 100 хувь нөхөн төлүүлж, хөрөнгө хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх зорилгоор эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдээгүй болно.

2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр

Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Төмөр зам дахь Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасгийг байгуулан тасгийн дарга 1, хэрэг бүртгэгч 2 орон тоотой батлагдсан.

Зөрчлийн Хэрэг бүртгэлтийн чиглэлээр 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2017 оны 9 дугаар сарын 21-ний хооронд иргэн хуулийн этгээдээс зөрчлийн шинжтэй 66 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 12,1 хувь буюу 8 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 21,2 хувь буюу 14 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 25,7 хувь буюу 17 гомдол мэдээллийг харъяаллын дагуу бусад байгууллагад шилжүүлж, 17 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 2 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ба хугацаа хэтэрч шалгагдаж байгаа гомдол мэдээлэл байхгүй байна.

Нийт гомдол мэдээллийн 91 хувь буюу гомдол мэдээллийг хуулийн анхны хугацаа болох ажлын 3 хоногт шалгаж шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэгч нар 8 хэрэгт зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж 2 хэргийг Мөрдөн байцаах тасагт шилжүүлэн, 6 хэрэгт шийтгэл оногдуулан ажиллагаа явуулсан бөгөөд одоо зөрчлийн хэргийн үлдэгдэлгүй байна.

Тус газрын хэрэг бүртгэх тасаг нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоос Дорноговь аймгийн Замын-Үүд сум хүртэл 6 аймаг 5 дүүргийн нутаг дэвсгэр дамнасан 1111 километр урт төмөр замын нутаг дэвсгэр болон тэдгээрийн объектуудад үйлдэгдсэн зөрчлийн гомдол, мэдээлэлүүдэд шалгах ажиллагаа явуулдаг бөгөөд дээрх үйлдэгдсэн зөрчлүүдийн 80 орчим хувь нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Түнхэл, Мандал, Баруун хараа сумдууд Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор сумдууд, Орхон аймгийн Орхонтуул, Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдуудад болон суудлын вагонд үйлдэгдсэн байна.

Тус тасгаас санаачлан Улаанбаатар төмөр замын Хяналтын албатай хамтран төмөр замын 1, 2, 3, 4 дүгээр ангиудад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан салбар нэгжид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 удаа яриа таниулга хийж, шинээр мөрдөгдөж байгаа зөрчлийн тухай хуулиар Толгойт өртөөний 64 ажилтан, Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын 20 ажилтан албан хаагчидад сургалт хийж ажилласан бөгөөд үүний үр дүнд гэмт хэрэг зөрчилд өртөх болон холбогдох байдал буурахад эерэгээр нөлөөлж байна.

Бүртгэгдсэн гомдол мэдээллийн талаар:

Тус цагдаагийн газар нь 2017 оны 3 дугаар улиралд хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас 306 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасныг өмнөх улиралтай харьцуулахад 179-р өссөн байна. Үүний 51 буюу 16,7 хувь нь гэмт хэргийн, 254 буюу 83,3 хувь нь зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийг төрлөөр нь авч үзвэл:

- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3,
- Бусдын биед халдах 6,
- Гүтгэх 2,
- Дээрэмдэх 1,
- Залилах 2,

- Хөрөнгө завших 1,
- Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 9,
- Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх 2,
- Хулгайлах **23**,
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5,
- Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг-1
- Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг-**31**,
- Бусад-**220** гомдол мэдээлэл тус тус бүртгэгдсэн байна.

Нийт хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй **51** гомдол, мэдээллийн **30** буюу 64,8 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, **18** буюу 35,2 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай шийдвэрлэсэн байна. Одоо үлдэгдэл **3** гомдол мэдээллийг шалгаж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг

Тус цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2017 оны 3 дугаар улиралд нийт **35** гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сарын мөн үеэс 20 хэргээр өссөн.

Гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх -1 /10.4.1/
- Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох -1 /10.6.1/
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах-2 /11.3.1/
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах-1 /11.5.1/
- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах-6 /11.6.1/
- Хулгайлах -10 /17.1.1-17.1.3/
- Дээрэмдэх-1 /17.2.2./
- Залилах -1 /17.3.1./
- Хөрөнгө завших -2 /17.4.1./
- Татвар төлөхөөс зайлс хийх -1 /18.3.1./
- Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх -4 /18.5.1./
- Хуурамч бичиг баримт үйлдэх,ашиглах -1 /23.2.1./
- Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих -1 /27.10.1./
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн,усан онгоц,агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах -3 /27.1.3.-27.10.1./

Үйлдэгдсэн гэмт хэргүүдийг газраар нь авч үзвэл:

- Гудамж талбайд -5 /УБ-2 өртөө орчим төмөр замын 399-р км, Толгойт өртөөний 202-р сумын арын татах зам,уб-эрээн чиглэлийн 34-р галт тэрэг/
- Олон нийтийн газарт -3 /УБЗҮТБ-н арын автомашины зогсоол, Сүхбаатар өртөөний зорчигчийн зааланд/
- Төрийн байгууллагад -3 /УБ хот дахь Гаалийн газрын Монгол транс гаалийн хяналтын бүсэд,тээврийн прокурорын газар /
- Нийтийн тээвэрт -9 /суудлын 275-р галт тэргэнд 4, суудлын 276-р галт тэргэнд 3, УБ-Хөх хот чиглэлийн 682-р галт тэргэнд 1, Шарын голын 705-р галт тэргэнд 1/

-Аж ахуйн нэгжид -10 /Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв,Төмөр замын Улаанбаатар татах хэсэгт, Зүтгүүрийн депо, Төмөр замын төв эмнэлэгийн хашаан дотор, ногоон зоорь/

-Гэр, орон сууцанд -1 /Баянбуурал амралтын газрын гэр байранд/

-Бусад газар -3 /Сүхбаатар өртөө, төмөр замын 399-р км-н 1-р зуут, 396-р км-н 5-р зуут/ гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гариг болон цагаар нь авч үзэхэд:

-Даваа гаригт -5		-06-14 цагт	-11
-Мягмар гаригт -8		-14-19 цагт	-10
-Лхагва гаригт -5		-19-22 цагт	-3
-Пүрэв гаригт -5		-22-06 цагт	-11
-Баасан гаригт -4			
-Бямба гаригт -3			
-Ням гаригт -5			

Хэргийн шийдвэрлэлт

Дээрх хугацаанд 7 хэрэг бүртгэлтийн хэрэг хааж, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 2 хэргийг хэрэг бүртгэлтийн хугацаа сунгаж, 25 хэрэг ажиллагаанд байна.

Зөрчлийн талаар

Зөрчлийн шинжтэй 254 гомдол мэдээллээс 37 гомдол, мэдээллийг зөрчлийн тухай хуульд зааснаар торгуулийн арга хэмжээ авч, 167 мэдээллийг хялбаршуулсан журмаар торгуулийн арга хэжээ авч, 7 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн шалгаж, 14 гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 19 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж одоо 10 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Энэ хугацаанд бэлэн бусаар 1646 хүнийг 30,037,500 төгрөгөөр торгосон байна.

2.4. Замын цагдаагийн хэсгийн чиглэлээр:

2017 оны 3 дугаар улиралд гудамж замд хуваарийн дагуу 1 офицер, 5 зохицуулагч ажиллаж согтуугаар автомашин жолоодсон 8-н зөрчил илрүүлэн Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст шилжүүлж ажилласан.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд амралтын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан зам тээврийн ослын талаар гомдол мэдээлэл 1-ийг хүлээн авч шийтгэврээр 1 хүнийг 25,000 төгрөгөөр торгож хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Төмөр замын гарам дээр 2017 оны 03 дугаар улиралд доорхи зам тээврийн осол гарсан байна. Үүнд:

2017.07.21-нд 07:05-нд Сонгино хайрхан дүүргийн нутагт байрлах Толгойт өртөөний төмөр замын салбар гарам дээр Хю/Сонота-6 маркын 77-05 УБУ улсын дугаартай автомашин сэлгээний 3102-р галт тэрэгтэй мөргөлдсөн зам тээврийн ослыг тус газрын Замын цагдаагийн хэсгийн зохицуулагч, цагдаагийн ахмад Ц.Оюунбаяр шалгаж шийдвэрлэсэн.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газраас ирүүлсэн ажлын чиглэл, “ОРОН НУТГИЙН ЗАМ –ХӨДӨЛГӨӨНИЙ СОЁЛ” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу салбар төлөвлөгөө гарган төмөр замын өртөө, зөрлөг хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэв журмын байцаагч нарт өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллах талаар зөвлөгөө өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Төмөр замын Улаанбаатар өртөөн дээр зохиогдсон “**Аюултай бүсийн дэглэм 2017**” хамтарсан зөвлөгөөнд анхаарах зүйлийн талаар мэдээлэл хийж 2017.08.20-ны өдрөөс 1 сарын хугацаатай төмөр замын хэмжээнд Аюултай бүсийн дэглэм хангуулах ажилд анхаарах зүйл, хэрэгжүүлэх ажилд мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Улаанбаатар төмөр замын тээврийн хэрэгсэлтэй 13 аж ахуйн нэгж, албан байгууллагуудын 186 тээврийн хэрэгслүүдийн техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулсан. Авто тээврийн үндэсний төвтэй хамтран төмөр замын байгууллагуудын тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношлогоонд цаг хугацаанд нь хамруулсан.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын арын автозогсоолын талбайд хэвтээ тэмдэглэл хийлгэх ажлыг зохион байгуулж, санхүү мөнгөний асуудлыг Төмөр замын хөрөнгөөр шийдвэрлүүлэн Улаанбаатар нэгтгэл ТӨҮГ-аар хийлгэсэн.

Иргэд жолооч нарт Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, Төмөр замын гармаар аюулгүй нэвтрүүлэх, Төмөр замын гармын зам засварын ажил хийгдэх хуваарийг танилцуулах зорилгоор FM-96.3 радио, Мэдээ.MN сайт дээр 2 удаа тус тус мэдээ, сэрэмжлүүлэг хүргүүлж хамтран ажилласан.

Төв аймгийн Баян сумын нугагт байрлах салбар төмөр замын 452-р км/ийн гарам, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 352, 396-р км/ийн гармын засварын ажил хийгдэх үед хөдөлгөөн зохицуулалт хийсэн.

Шинэ хичээлийн жилийн нээлттэй холбоотой улсын дугаарыг 08 дугаар сарын 26, 27-ны Бямба, Ням гаригт дугаар хязгаарлах үед хөдөлгөөн зохицуулалт, хяналт шалгалт хийж ажилласан.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал, Зам засварын машинт станц зэрэг байгууллагын жолооч, техникийн ажилтан нарт Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм, Монгол улсын Зөрчлийн тухай хуулиар 2 цагийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 45 ажилтан хамрагдсан.

Улаанбаатар төмөр замын хэмжээнд жолооч орон тоон дээр ажилд орох хүсэлт гаргасан 16 иргэний жолоочийн лавлагаа авч тэднээс Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, ур чадварын шалгалтыг авч дүнг нэгтгэн төмөр замын автобаазын удирдлагад танилцуулж ажилласан.

Автомашины урсгал хөдөлгөөн, ачаалал ихтэй төмөр замын 406, 407, 396-р км-ийн гармууд дээр зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа зохицуулагчийг хуваарийн дагуу ажиллуулж байна.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал орчмоос хөдөө орон нутагт зөвшөөрөлгүй зорчигч тээвэрлэсэн 8 жолоочийн бичиг баримтыг дахин энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гаргуулж ажилласан.

Замын цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар

“Анхаар галт тэрэг” шторк хийлгэж, Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын хажуугийн Лед дэлгэцээр иргэд жолооч нарт сурталчилж байна.

Төмөр замын гарам дээр осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар “АНХААР ЗОГС ГАЛТ ТЭРЭГНЭЭС БОЛГООМЖИЛ” зурагт санамж, материал 200 ширхэгийг иргэд, жолооч нарт тараан ажилласан.

Бусад ажлын талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Үндэсний их баяр наадам, Япон улсын парламентийн дарга Т.Оошима тэргүүтэй зочин төлөөлөгч, Улаанбаатар төмөр замын мэрэгжлийн өдөрлөг Баянзүрх дүүргийн нутагт зохиогдох үед хамгаалалт зохицуулалтанд давхардсан тоогоор 1 офицер, 6 зохицуулагч 42/416 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажилласан.

Цагдаагийн газрын нийт 198 алба хаагчдаас алба ба амины тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодохгүй байх талаар 1 удаа баталгаа авч ажилласан.

ЦЕГ, Нийтийн хэв журам хамгаалах газар, Замын цагдаагийн албанаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, хөтөлбөрийн биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Төмөр замын хяналтын албанд төмөр замын гармууд дээр галт тэрэг саатуулсан, гарам зөрчсөн зөрчлийн шийдвэрлэлтийг сараар гаргаж хүргүүлсэн.

2.5. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь тасгийн дарга-1, ахлах байцаагч-2, ЗЦАЗ-1, офицер-15, ахлагч-110, нийт-136 алба хаагчтайгаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажил үүргээ гүйцэтгэлээ.

2017 оны 3 дугаар улиралд Зөрчлийн тухай хуулиар нийт 2406 зөрчилд торгуулийн хуудсаар 42,096,496 төгрөгний торгууль оногдуулж, х/ч Б.Энхбаатар 14 д/ч Э.Шинэхүү 12, а/д А.Багатамир 10, а/д М.Хүрэлбаатар 5 захиргааны зөрчил тус тус шалган шийдвэрлэсэн. Үүнд:

Урд чиглэлд Сайншанд дэд хэсгийн ажил: Замын үүд, Чойр, Айраг, Далан, Сайншанд зангилаадын 10 цагдаагийн алба хаагч “Зөрчлийн хууль”-иар хялбаршуулсан журмаар нийт 27 хүнийг 405000 төгрөгний торгуулийн хуудсаар арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Хойд чиглэлд Дархан дэд хэсгийн ажил: Сүхбаатар, Дархан, Эрдэнэт, Зүүнхараа, Мандал өртөө зангилаадын алба хаагчид 38 хүнийг 850000 төгрөгөөр торгон арга хэмжээ авч, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 71 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэн өгч, 3 эрүүгийн хэрэг илрүүлэн харьяалалын дагуу шилжүүлэн, эрэн сурвалжлагдаж байсан 1 хүнийг олж тогтоосон байна.

МУ-ын “Тамхины хяналтын хууль”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УБТЗ-ын Тээврийн хяналтын алба, БГДЗДТГ-ын хүнс худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран төмөр замын бүсэд тамхи худалдан борлуулдаг аж ахуй, этгээдийн үйл ажиллагаанд

хяналт тавихаар “Хяналт 9 сар” тусгай арга хэмжээг зохион байгуулж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын 1 дүгээр зэрэглэлд шилжүүлж ажиллуулах тухай” А/146 мөн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Цагдаагийн түр хүрээ байгуулах тухай” А/147 дугаар тушаал, Нийтийн хэв журам хамгаалах газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/22 дугаар тушаалыг үндэслэн тус цагдаагийн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 дахь шатны санал хураалтын болон Тулгар төрийн 2226, Их Монгол улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеийн олон нийтийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бие бүрэлдэхүүнийг 2017 оны 07 сарын 06-ны өдрийн 09:00 цагаас 2017 оны 07 сарын 14-ны өдрийн 09:00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын 1 дүгээр зэрэгт шилжүүлж жижүүрийн шуурхай удирдлага, албадан эрүүлжүүлэх байрны хуваарь, эргүүл, жижүүрийн томилгоо, суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хуваарийг баталж газрын бие бүрэлдэхүүнд 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр дээрх тушаал, үүргийг танилцуулж тус цагдаагийн газрын даргаас алба хаагчдад үүрэг чиглэл өгсөн. Тус цагдаагийн газрын нийт 165 алба хаагч, 6 автомашинтай үүрэг гүйцэтгэсэн. Мөн 08 дугаар сарын 04-с 05-ны өдрүүдэд Төмөр замчдын баярын хамгаалалтанд бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан.

2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаас ирүүлсэн 2/287 тоот ажлын чиглэлийн дагуу хийсэн ажлыг 14 заалтаар гаргаж хүргүүлсэн. Мөн тэргүүн дэд даргаас ирүүлсэн 2017 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 2/424 тоот албан бичгийн хариуг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг Суудлын вагон депогийн даргад 2017 оны 33а/1122, тасалбарын төвд 33а/1120, Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын даргад 33а/1121 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Улаанбаатар төмөр зам болон өртөө, зангилаадад ажиллаж байгаа төмөр замчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, Архины хор хөнөөл, түүний хор уршигийн талаар 2, Тодорхой төрлийн гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар 2, Төмөр замын аюултай бүсийн дэглэмийн чиглэлээр 2, шинээр батлагдан гарсан захиргааны зөрчлийн тухай хуулиар 4, Төмөр замын гарам нэвтрэх журмаар 2 удаа нийт 15 удаагийн сургалтыг зохион байгуулж 350 хүн хамрагдаж 8 төрлийн 2310 ширхэг тараах материал, санамж, сэрэмжлүүлэг тараан ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 зөвлөмж, 3 албан мэдэгдэл бичиж 2-д хариу авсан.

Шинээр батлагдан гарсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, ахмад настны тухай хуулийн эмхтгэлийг “Ган зам” сонины 2017 оны 07 дугаар сарын 4-ний өдрийн 27, 28, 29-р дугаар, төмөр замын аюултай бүсийн талаар сэрэмжлүүлэгийг Ган зам сонины 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 38 –р дугаарт нийтлүүлж иргэд, төмөр замчдад

гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгон ажиллаа.

Шинэчлэгдэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, төмөр замын аюултай бүс түүнээс урьдчилан сэргийлэх, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 телевизэд 10 удаа мэдээлэл өгсөн нь 25 удаагийн давтамжтай гарч иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаа

Төмөр замын аюултай бүсийн чиглэлээр хийгдсэн 10 төрлийн богино хэмжээний видео шторкийг Улаанбаатар зоригч үйлчилгээний төв буудал болон Дархан, сэлэнгэ, Замын-үүд, Сайншандын зорчигч үйлчилгээний төв буудал, мөн орон нутгийн телевизээр тогтмол гарган гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

2.7. Эрүүлжүүлэх байрны ажлын үйл ажиллагааны талаар:

Тус газрын албадан эрүүлжүүлэх байр 4 эмч, 8 цагдаагийн бүрэлдэхүүнтэй ажиллан, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” хууль, ЦБҮАЖ код 630 “Албадан эрүүлжүүлэх” журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг ханган зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна.

Албадан эрүүлжүүлэх байр нь 3 дугаар улиралд согтууруулах ундааны зүйл хэрэглэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 580 эмэгтэйг хүлээн авч эрүүлжүүлж, 566 хүнээс 2,348,900 төгрөгний төлбөр гаргуулан авч санхүүгийн албанд тушаасан. Эрүүлжүүлэгдсэн иргэдийн төлбөр төлөлт 97,5 %-тай байна.

Албадан эрүүлжүүлэгдсэн 580 хүнд архи согтууруулах ундааны хор хөнөөлийн талаар яриа таниулга хийж, 55 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламжийг шуурхай үзүүлэн шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламжийн төв 103-т дуудлага өгч 21 иргэний эрүүл мэндийг үзүүлж эрүүлжүүлсэн иргэдийн амь нас эрүүл мэндийг сахин хамгаалж ямар нэгэн эрсдэлгүй ажилласан. Согтууруулдах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн, биеэ авч явах чадваргүй 9 иргэнийг ар гэр асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

3.1. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ээр газрын нийт алба хаагчдад сургалт орж алба хаагч нэг бүрээс баталгаа гаргуулан авсан. Ган зам пресс хэвлэлийн газартай хамтран “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ээр өврийн ном хэлбэрээр хэвлүүлэн алба хаагч нарт уншиж судлуулахаар тараав.

3.2. Сахилга ёс зүйн зөрчлийн мэдээ

Тус цагдаагийн газарт 2016 оны 3 дугаар улиралд сахилга ёс зүйн зөрчилгүй байсан бол энэ оны 3 дугаар улирлын хэмжээнд 3 зөрчилд 3 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь урд оны мөн үетэй харьцуулж үзэхэд 3 % өссөн байна. Сахилгын зөрчил

гаргасан алба хаагчдад тасгийн дарга нар албаны шалгалт явуулж газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сахилгын арга хэмжээ ногдуулсан.

3.3. Дотооддоо зохион байгуулсан сургалт

2017 оны албаны сургалтыг ЦЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2017 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, Б/257 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр 2016-2019”, Цагдаагийн байгууллагаас Эрх зүйн сургалт сурталт, сурталчилгааны чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, Төмөр зам дахь цагдаагийн газрын даргын баталсан газрын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн албаны сургалтын төлөвлөгөөг удирдлага болгон зохион байгууллаа.

Албаны сургалтын чанар, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээг удирдлагаар хангах, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор эхний хагас жилийн тайланг, санал асуулгын хуудсын дүнгийн хамт газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, А/29 тоот тушаалаар “Сургалтын баг” байгуулж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэв.

Газрын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа албаны сургалтын чанар, үр дүн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор 2017.07.06-ны өдөр 91 алба хаагчаас 6 нээлттэй, 2 хаалттай асуулгаар санал асуулга авахад дараахь үр дүн гарсан бөгөөд тус газар зохион байгуулагдаж байгаа сургалтын чанарыг эерэгээр үнэлсэн үнэлэмж нь 86,6% байгаа ба энэ нь санал асуулгад хамрагдсан алба хаагчдын 92%-ийн хэрэгцээ шаардлагад бүрэн болон зарим талаар нийцэж байгаагаар харагдаж байна. Түүнчлэн алба хаагчдаас бүтээлч, практик дадал олгох болон бүлгээр ажиллах сургалтууд зохион байгуулбал үр дүнтэй явагдана гэж, мөн ном сурах бичиг, гарын авлага, практик сургалтын хэрэгцээ шаардлага их, хууль зүйн чиглэлийн сургалт түлхүү авч байхаа илэрхийлсэн байна.

Газрын 194 алба хаагчид албаны сургалтын дэвтрийг нэгдсэн журмаар олгож, хичээлийн конспект, тэмдэглэгээнд тасгийн дарга нар хяналт тавьж хэвшлээ.

Тус газрын танхимын сургалтыг дараахь чиглэлээр зохион байгуулсан бөгөөд үүнд:

- Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 4 удаа 8 цаг 285 алба хаагч
- Алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг 4 удаа 8 цаг 286 алба хаагч
- Мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалтыг 6 удаа 12 цаг 172 алба хаагч давхардсан тоогоор хамрагдсан байна.

Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг дээшлүүлэх зорилтот сургалтын хүрээнд ЦЕГ-ын даргын А/129 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сахилгын дүрэм”, ЦЕГ-ын даргын А/99 тоот тушаалаар батлагдсан “Ёс зүйн төлбөртэй сургалт явуулах хөтөлбөр” сэдвүүдээр газрын бие бүрэлдэхүүнд болон НХЖХТасгийн алба хаагчдад 3 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 180 алба хаагч хамрагдсан байна.

Эрх зүйн сургалт сурталчилгааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зөрчлийн тухай хууль” болон “Эрүүгийн хууль”-аар тус тус сургалт зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах ажлын хүрээнд ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс боловсруулан гаргасан “Байгууллагын соёл,

үнэт зүйлсийг төлөвшүүлэх нь”, Дотоод ажил, аюлгүй байдал, стратеги ба терроризм”, “Удирдах ажилтны ёс зүй, соёл” сэдэвт цахим сургалтанд тус газрын 9 ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн хамрагджээ.

Зөрчлийн болон зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан тээврийн прокурорын газартай хамтран доктор, профессор Б.Батзоригийг урьж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах эрх бүхий алба хаагчдыг бүрэн хамруулан 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр тус цагдаагийн газрын зааланд сургалтыг зохион явуулсан. Мөн ТЗНЭ-ийн Сургалтын албатай хамтран Албадан эрүүлжүүлэх байрны эмч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж эрүүлжүүлэх байрны эмч нарыг хамрууллаа.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэмжээнд “Түрэн гаргах бүлгийн сургалт”-ыг 2 удаа хэсэгчлэн зохион байгуулав.

2017 оны 3 дугаар улиралд шинэчлэгдэн батлагдсан эрх зүйн актаар “АХА” тэмцээн”, “Албаны сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох”, “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга”-аар тус тус хэлэлцүүлэг зохион байгуулав.

Тайлангийн хугацаанд “Зөрчлийн тухай хууль”-аар алба хаагчдад болон иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор гарын авлага 2, тест 1-ийг боловсруулан зохиомол орчин 1 удаа бүрдүүлж, аудио бичлэг 3 удаа ашигласан байна.

Түүнчлэн сургалттай холбоотой ЦЕГ-ын харьяа нэгж албадаас ирүүлсэн 36 албан бичгийг газрын бие бүрэлдэхүүнд мэдээлж, мэдээллээр хангаж ажилласан.

ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвийн ЦЕГ-ын даргын 2017 оны б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу 2017 оны 9, 10 сард сургалтанд хамрагдах 15 алба хаагчийн, ХСИС-ийн Герман хэлний анхан шатны дамжаанд хамрагдах 1 алба хаагчийн, Эдийн аюулгүй байдлын магистрын сургалтанд 1 алба хаагчийн, Хүний эрхийг хангах сургагч багш бэлтгэх сургалтанд 1 алба хаагчийн нэрийг тус тус хүргүүлж ажилласан байна.

Сургагч багшийн хүрээнд сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос нь Сургалтын нэгдсэн төвд “Галт зэвсэгтэй ажиллах үеийн сэтгэл зүйн бэлтгэл” сэдэвт 2 цагийн сургалт орсон.

3.4. Бусад нэгж байгууллагаас зохион байгуулсан сургалт зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал:

Мөн ЦЕГ-ын харьяа нэгж, албадаас зохион байгуулсан:

➤ СААА-ны “Цэргийн хээрийн гал тогоо КП ашиглах” сургалтанд аж ахуйн ажилтан а/х О.Гомбосүрэн

➤ ЭЦА-ны “Монгол улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлага” сургалтанд эрүүгийн ахлах мөрдөгч, а/д Э.Бямбадэлгэр, дэд хэсгийн ахлах төлөөлөгч, а/х Л.Эрдэмбилэг, Я.Амарзаяа, эрүүгийн мөрдөгч х/ч П.Амгалансайхан, а/х Ж.Дэлгэрсайхан, а/д Э.Бат-Энэрэл, д/ч Ч.Анхбаяр, ГБХХЭГХУСМэргэжилтэн, д/а Ц.Жаргал

- ГХХХ-ийн “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг танилцуулах” сургалтанд эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэрэг бүртгэгч, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хэв журмын ахлах болон байцаагч нарын 27 алба хаагч
- МБГ-ын “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн сургалтанд х/ч Г.Сайнжаргал, а/д Ж.Гэрэлт-од
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх нь сургалтанд х/ч Г.Сайнжаргал
- “Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх” сургалтанд а/д Ж.Гэрэлт-Од
- СНТ-ийн “Зэрлэг ан амьтны хууль бус худалдаа” сургалтанд хэсгийн төлөөлөгч, а/х Ж.Дэлгэрсайхан
- ЦЕГ-ын “Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл”-ийн хэлэлцүүлэгт а/д Т.Энхтүвшин, а/а Ц.Чимэдрэгзэн нар тус тус хамрагдсан байна.
- Тус газрын алба хаагчдаас ХСИС-ийн цагдаагийн сургуулийн эчнээ ангид 7 алба хаагч суралцаж байна.

3.5. Соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ.

2017 оны Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд “Гар бөмбөгийн аварга” шалгаруулах тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 16-ы өдөр 73 дугаар сургуулийн дотуур байрны спорт зааланд, Хэрэг бүртгэх тасгаас шинээр батлагдсан хууль дүрэм болон танин мэдэхгүйн АХА тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 22-ы өдөр тус тус зохион байгуулав. ЦЕГ-ын 2017 оны “Дугуйн аварга шалгаруулах” тэмцээнд алба хаагчид 12 гишүүнтэй баг бүрдүүлж амжилттай оролцон оролцон хоёрдугаар байр эзэлж “Мөнгөн” медаль авав.

3.6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар.

Шинээр батлагдан гарсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, ахмад настны тухай хуулийн эмхтгэлийг “Ган зам” сонины 2017 оны 07 дугаар сарын 4-ний өдрийн 27, 28, 29-р, төмөр замын аюултай бүсийн талаар сэрэмжлүүлэгийг Ган зам сонины 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 38–р дугаарт нийтлүүлж иргэд, төмөр замчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгон ажиллаа.

Шинэчлэгдэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, төмөр замын аюултай бүс түүнээс урьдчилан сэргийлэх, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 телевизэд 10 удаа мэдээлэл өгсөн нь 25 удаагийн давтамжтай гарч иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаа

Төмөр замын аюултай бүсийн чиглэлээр хийгдсэн 10 төрлийн богино хэмжээний видео шторкийг улаанбаатар зоригч үйлчилгээний төв буудал болон өртөө Дархан, сэлэнгэ, Замын-үүд, сайншандын зорчигч үйлчилгээний төв буудал, мөн орон нутгийн телевизээр тогтмол гарган гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

3.7. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ:

Шинээр томилогдсон 3 алба хаагч бүрийн 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын мэдээллийн санд шинэчлэн оруулав.

Цагдаагийн алба хаагчдын сахилга ёс зүй, авлига хээл хахууль шан харамж, хүнд суртал, цагдаагийн газар, алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой гомдол

мэдээллийг хүлээн авах Цагдаагийн ерөнхий газрын 126 дугаарын утасны зурагт хуудас болон жижүүрийн шуурхай албанд ажиллаж буй 24100 дугаарын утасны талаар газрын иргэдийн хүлээлгийн танхим, орон нутгийн зорчигч үйлчилгээний төв буудал, газрын railway.police.gov.mn цахим хуудсанд байрлуулан иргэдэд сурталчилж ажилласан.

Тус цагдаагийн газрын алба хаагчид авлига ашиг сонирхлын зөрчилд холбогдоогүй бөгөөд, энэ талаар гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Дөрөв: Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар
4.1. Байгууллагын санхүү, бүртгэл, хангамж үйлчилгээний талаар:

Тус цагдаагийн газар нь ЦЕГ-ын даргын 2016-11-23-ны №6/646 тушаалаар цагдаагийн газар болж, албан тушаал цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлуулж, төсвийн 107 алба хаагч, гэрээтийн 95 алба хаагч, нийт 202 орон тоотойгоор үүрэг гүйцэтгэхээс, 3-улирлын байдлаар ахлагчийн орон тоо бүрэн, офицерийн 2 орон тоо дутуу ажилласан.


2017 онд 2 тэрбум 544,4 сая төгрөгийн төсвийн санхүүжилт батлуулж зохих журмын дагуу зарцуулж байна.

2017 оны 3 дугаар улиралын байдлаар улсын төсвийн санхүүжилт 974,254,700 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу цагдаагийн алба хаагч гэрээгээр ажиллуулах гэрээний орлого 955,061,529 төгрөг, саатуулах байрны орлого 8,109,850 төгрөг, цайны газрын орлого 1,800,000 төгрөг, хувь хүнээс авах авлага 29,500 төгрөг нийт 965,000,879 төгрөгийг төвлөрүүлэн 1,858,492,241 төгрөгийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

Санхүүгийн 2016.2017 оны 3 улирлын орлогын харьцуулалт:

Орлого:

Үзүүлэлт	2016 он	2017 он
Төсвийн санхүүжилт	884,852,500.00	974,254,700.00
Гэрээтийн орлого, болон бусад орлого	981,880,771.00	965,000,879.23



Үүнд: Цалин хөлс нэмэгдэл урамшилд 957,086,509 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх ЭМД, НДШ-д 31,268,700 төгрөг.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: гэрэл цахилгааны зардалд 5,895,550 төгрөг, түлш халаалтын зардалд 9,400,411 төгрөг, цэвэр бохир усны зардалд 5,164,197 төгрөг, байрны түрээсийн зардалд 27,765,353 төгрөг

Хангамж бараа материалын зардал: бичиг хэргийн зардалд 692,800 төгрөг, шуудан холбооны зардалд 3,614,326 төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 994,305 төгрөг

Нормативт зардал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 633,465 төгрөг, Хоол, хүнсэнд 10,018,600 төгрөг

Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 224,400 төгрөг, урсгал засварт 2,857,000 төгрөг

Дотоод албан томилолтын зардалд 969,000 төгрөг.

Бараа, үйлчилгээний бусад зардал: Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 525,000 төгрөг

Харуул хамгаалалтын зардал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 798,502,623 төгрөг тус тус зарцуулсан.

Байр ашиглалттай холбоотой зардал хүрэхгүй байгаа учраас дулааныг 1 сарын өмнөөс хязгаарлаж, тэвчиж болох ашиглалтын зардлыг хэмнэн ажиллав.

2017 оны 1-дүгээр сарын 01-ний өдөр УБТЗ нийгэмлэгтэй 14 офицер, 81 цагдаа, нийт 95 цагдаагийн алба хаагч ажиллуулахаар 1 тэрбум 276,7 сая төгрөгийн “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан. Өмнөх онтой харьцуулахад 47,5 сая төгрөг буюу 3,9%-иар нэмэгдүүлж гэрээг батлуулсан. Гэрээний дүн нэмэгдсэн шалтгаан нь дүрэмт хувцас, хэрэглэлийн үнэлгээ нь нэг алба хаагчид 3,5-4,0 сая төгрөгийн үнэлгээтэй, “Цагдаагийн алба хаагч ажиллуулах гэрээ”-ний 2014-2015 оны төсөвт хувцасны зардлын тодорхой хэсгийг олгож байсан ч 2016 онд хасаж олгосноос хүйтэн, сэрүүний улиралд зориулалтын дулаан хувцсаар хангагдаагүйгээс алба хаагчдын дунд өвчлөл ихсэж, үүнээс үүдэлтэй төрийн албаны тасралтгүй ажиллах нөхцөл байдал алдагдахад хүрсэн. Иймд Улаанбаатар төмөр замын удирдлагуудтай уулзаж, холбогдох хууль, нөхцөл байдлыг танилцуулсаны үр дүнд 2017 оны гэрээнд хувцасны зардалд 38,000,000 төгрөгийг нэмж батлуулсан. Мөн Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу удаан жилийн нэмэгдлийг ажилласан жилээс нь хамааруулан 10%,25%,45% -иар гэрээнд тусгаж, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн.

2017 оны 3-р улиралд цаашид ашиглагдах боломжгүй, ашиглалтын хугацаа нь дууссан 6,842,130 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,875,032 төгрөгийн тавилга аж ахуйн эд хогшил, нийт 10,717,162 төгрөгийн үндсэн хөрөнгө, 19,381,617 төгрөгийн бараа материалыг актлуулахаар саналыг ЦЕГ-ын Санхүү аж ахуйн албанд 31а/445 тоот албан

бичгээр хүргүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албаны даргын 2017 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 122 дугаар “Бараа материал актлах тухай” тушаалын дагуу бараа материалын дансны 61 нэр төрлийн 424 ширхэг 19,382,116.72 /арван есөн сая гурван зуун наян хоёр мянга нэг зуун арван зургаан төгрөг далан хоёр/ мөнгөний тусгай хэрэгсэл, бараа материал, ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний №А/118 тушаалаар 10,717,162 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасч, Санхүү хангамжийн төвд хөрөнгө актлах комиссын гишүүдэд хүлээлгэн өгсөн.

2017 оны 3 улирлын байдлаар байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай хөрөнгийн судалгааг гаргаж, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэн 3,027,900 төгрөгийн үндсэн хөрөнгийг гэрээтийн орлогоор худалдан авч, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь хэсэгт заасны дагуу газрын даргын тушаалаар үндсэн хөрөнгийн дансанд орлого авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2017 оны 05 дугаар сарын 31-ний 33/а969 албан тоотоор худалдан авсан үндсэн хөрөнгийг жагсаалтыг хүргүүлсэн

4.2. Шилэн дансны ил тод байдлын талаар:

Тус цагдаагийн газар нь Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу шилэн дансны цахим хуудас, байгууллагын вэб сайт, газрын санхүүгийн мэдээллийн самбарт цаг хугацаанд мэдээллээ. Цагдаагийн алба, газар, хэлтэс, тасаг төвүүдийн 2017 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр 99%-тай үнэлэгдсэн.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн хэсэг рүү орж, мэдээлэл бүрэн байршуулсан эсэхээ хянаж, 3-р улирлын аудитын тайланг цахимаар илгээсэн.

Нийгмийн даатгалын тайлан, татварын тайланг цаг хугацаанд нь гаргаж, өр авлагагүй ажилласан.

2017 оны 3 улирлын байдлаар няравт таван мянган төгрөгийн 962 ширхэг торгуулийн тасалбар, 90 ширхэг шийтгэвэр, алба хаагчдын гар дээр 851 ширхэг торгуулийн тасалбар, 58 ширхэг шийтгэвэрийн үлдэгдэлтэй байна. Торгууль шийтгэвэрийн дансанд 24,853,200 төгрөгийн орлого төвлөрсөн байна. Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн орлого 99,689,500 төгрөг байна.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

5.1. Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр.

Гэрээт алба хаагчдын нормын дүрэмт хувцасны зардлыг төсөвт тусгуулсанаар гэрээт алба хаагчдын цагдаа хувцасны мөнгийг цаг тухайд нь шийдэж хувцсыг олгуулж, алба хаагчдын ажиллах нөхцөл аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын ариутгал халдваргүйтгэлийг “НЖБГ” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан албадан эрүүлжүүлэх байрны стандартыг хангах, алба хаагчдын ажиллах орчин болон эрүүлжүүлэгдсэн иргэдэд цэвэр аюулгүй орчинд үйлчлэх зорилгоор 2017 оны 07 сарын 6, 21-ний өдөр 2 удаа хийлгэсэн.

Түүнчлэн “Алба хаагчдын нийгмийн асуудал, эрүүл мэндийн байдал, тэдний ахуй амьдрал, ажиллах орчин нөхцлийн судалгаа”-г шинээр, “Цалингийн зээлийн судалгаа”, “Орон сууцны зээлтэй алба хаагчдын судалгаа”, “Хүүхдийн судалгаа”-г тус тус 3 дугаар улирлын байдлаар шинэчлэн гаргасан байна. Мөн БЗД-10 хорооны нутаг дэвгэрт байрлах “Цагдаа хотхон-Амгалан” цогцолбор хороололд байрны захиалга”-д хамрагдах хүсэлтэй 20 алба хаагчийн судалгааг гарган ажилласан байна.

5.2. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид ажилд гарахаасаа өмнө эрүүлжүүлэх байрны эмчээр артерийн даралтаа үзүүлдэг нь манай газрын хувьд хэвшмэл болсон ажил бөгөөд газрын дарга, ерөнхий эргүүлүүд эрүүл мэндийн хуудастай цаг тухай бүр нь танилцан ажилладаг.

Мөн алба хаагчид жил бүр урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгт хамрагддаг жишгээр энэ жилийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ 09 дүгээр сарын 04-08-ны хооронд Төмөр замын төв эмнэлэгт явагдаж 98 алба хаагч хамрагдсан.

“Монголын эрдэст ус” ХХК-ны санаачилгаар цэвэр усны хэрэглээ болон эрүүл мэндийн ач холбогдлын талаар алба хаагчдад яриа таниулга хийсэн.

Төмөр замын төв эмнэлгийн халдвартын тасагтай хамтран “Тарваган тахал”-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилгад тус цагдаагийн газарт эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг 40 алба хаагчийг хамруулсан.

Ажлын байрны хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж Тээврийн хяналтын хэлтэстэй хамтран алба хаагч нарт дасгал хөдөлгөөний зурагт хуудсыг бялдаржуулах танхимд байршуулан ажлын байранд дасгал хөдөлгөөнийг тогтмол хийхийг алба хаагч нарт зөвлөн ажиллаж байна.

5.3. Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Алба хаагч аюулгүй байдлаа хангаж, эргүүл шалгалт хийхдээ болон гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэлд очихдоо заавал хоёроороо явах, нэг бүрийн тусгай хэрэгслийг биедээ авч явах, албан үүрэг гүйцэтгэхдээ агсамж зүүх, суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид гэмт хэрэг зөрчилд холбогдсон болон хохирсон иргэдтэй аль болох нөхцөл байдалд уялдуулан харилцахдаа албаны харилцааг эрхэмлэн сул үг хэрэглэхгүй, асуудлыг дэвэргэхгүй шийдвэрлэж байх, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн бол галт тэрэг хамгийн ойр зогсох өртөө, зангилаадын жижүүрийн цагдаа, хэсгийн төлөөлөгч, хэв журмын байцаагч нарт боломжтой бүх хэлбэрээр /харилцаа холбоогоор/ мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авах, хуяглан хүргэх ажиллагааг зөрчихгүй байж эргүүлийн үүргийг гүйцэтгэх, ямар нэгэн албан тушаалтан болон танил талаар дамжуулан гуйсан гэмт хэрэгт холбогдсон этгээдийг авч явахгүй байх, гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн болон мансууруулах сэтгэцэд нөлөөлөх зүйл хэрэглэсэн байж болзошгүй иргэнийг шалгахдаа алба хаагч иргэдийн болон өөрийн аюулгүй байдлаа хангаж хутга мэс, өөр бусдад аюул учруулж болох зүйлс байгаа эсэхийг шалгахдаа нөхцөл байдал, газар оронд үнэлэлт дүгнэлт өгч байх, гэмт хэрэг зөрчилд холбогдсон этгээд галт тэрэг явж байхад галт тэргэн дээгүүр зугатах тохиолдол гардаг, энэ үед араас нь гарч хөөхгүй байх, галт тэрэгний гаднаас зүүгдсэн үед мөн гарч өөрт болон бусдад аюултай үйлдэл хийхгүй байх, аль болох галт тэрэгний даргатай холбогдож шаардлагатай арга хэмжээг авах, ажлын онцлогоос хамаарч хээр гадаа, зэлүүд газар хэргийн газрын хамгаалалтанд ажиллах шаардлага гардаг тул алба хаагч албаны болон

хувийн бэлтгэлийг сайтар хангаж хэвших, Үүнд: гар чийдэн, цахилгаан бороохой, шүдэнз, шүгэл, дулаан хувцас, цэнэгтэй гар утас, гэх мэт шаардлагатай бусад зүйлстэй байх, алба хаагч албан үүрэг гүйцэтгэхдээ болон амарч байхдаа, ажлаас буугаад явах үедээ цагдаагийн газрын байранд байршуулсан зориулалтын хувцас солих шүүгээнд хувцсаа сольж хэвших, албаны бэлтгэлийн танхимд 7 хоногт 1-ээс доошгүй удаа орж албаны бэлтгэлийн сургалт, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх дадлага сургалтанд тасралтгүй хамрагдах талаар үүрэг зааварчилгаа өгч биелэлтийг өдөр бүр шалгаж үр дүнг тооцож хэвшсэн.

Алба хаагчдыг албан үүрэг гүйцэтгэх болон гүйцэтгэж ирээд цагдаагийн газраас зохион байгуулсан зориулалтын хувцасны шүүгээнд хувцсыг солиулж хэвшсэн. Тухайн өдрийн жижүүрийн ахлах офицер, ерөнхий эргүүлүүд байгууллагын болон алба хаагчийн аюулгүй байдалд хяналт тавьж гарсан зөрчлийг шадар даргад нь танилцуулж зөрчлийг арилгахаас гадна алба хаагчдын хувцас солих шүүгээг өдөр бүр шалгаж байна. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэн үед хэрхэн ажиллах, хамтран үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид аюул тохиолдсон үед өөрийгөө болон хамтрагчийнхаа аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах чиглэлээр дадлага сургуулилтыг цагдаагийн газрын арын талбайд 2 удаа зохион байгуулж илтгэх хуудсыг ЦЕГ-н НХЖХА, ОНАБХА-нд явуулсан. Газар хөдлөлт гамшгийн үед албаны байрнаас хэрхэн түргэн шуурхай, аюулгүй байдлаа ханган гарч аюулгүй газар цугларах дадлага сургалтыг цагдаагийн газрын байранд зохион байгуулж ажиллаа. Газрын ерөнхий эргүүлээр тасгийн дарга, ахлахуудыг томилон, тухайн өдрийн жижүүрийн бүрэлдэхүүн, жижүүр, эргүүл болон суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан артерын даралтыг үзүүлж, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг драйгераар шалгуулан ажил үүргийг нь гүйцэтгүүлэх, албаны автомашины цаг ашиглалтын дэвтэрт ерөнхий эргүүлүүд тогтмол хяналт тавьж, өдөр тутам газрын даргад танилцуулж хэвшсэн. Мөн байгууллагын аюулгүй байдлыг хангах үүднээс байгууллагын цонхнуудруу авирч очих боломжтой байсан моднуудыг тайрсан. Мөн байгууллагын аюулгүй байдлыг хангах хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 23 өрөөний цонхыг төмөр сараалжаар бэхэлсэн.

Мөн аж ахуйн ажилтан, цагдаагийн ахмад Г.Гомбосүрэн хойд чиглэлийн дэд хэсэг хариуцсан ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад Л.Эрдэмбилэг нар 09 дүгээр сарын 20-оос 24-ний өдрүүдэд газрын төв байр болон хойд чиглэлийн Мандал, Түнх, Зүүнхараа, Баруунхараа, Салхит, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ зэрэг өртөө зангилаадад байрлах алба хаагчдын байр орон сууцны чанар аюулгүй байдал, засвар үйлчилгээ шаардлагатай эсэх талаар судалгааг гаргаж газрын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажилласан.

Журам сахиулагч цагдаа өдөр бүр ажил тарахад өрөөнүүдийн лац ломыг шалган жижүүрийн ахлахад хүлээлгэн өгч хэвшсэн.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

6.1 Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байдал; /код-110/

Тус цагдаагийн газар нь 2017 оны үйл ажиллагаандаа Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг удирдлага болгон, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны А/81 тушаалаар баталсан “Хяналт шинжилгээ хийх аргачлал”, ЦЕГ-ын даргын 2014 оны 842 дугаар тушаалаар

баталсан “Цагдаагийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний /код-110/ журам”-ыг тус тус баримтлан ажиллаж байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ хийх баримт бичгийн жагсаалтаас өнөөдрийн байдлаар дээд байгууллагаас төлөвлөлт, гүйцэтгэлийн шалгуурыг тодорхойлсон цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

6.2. Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар:

Хэрэг бүртгэгч, мөрдөгч нарын өөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 4/б303, 4/954, 4/1166 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн “Алба хаагч өөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр” үүрэг чиглэлийг тухай бүр нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт танилцуулан сэжигтэн, яллагдагчийг тус бүрээр авч байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулахдаа, төлөвлөгөө гарган, нэг бүрийн тусгай хэрэгсэл болох бугуйн гавыг сэжигтэн яллагдагчид хэрэглэж, алба хаагч нарыг хамгаалах хантааз болон хутганаас хамгаалах бээлийг өмсүүлж, тасгийн зарлага цагдааг оролцуулж, сэжигтэн яллагдагчаас байцаалт авах үед зэвсэг зэвсэгийн чанартай зүйлс ширээн дээр байрлуулахгүй, хэрэг бүртгэгч, мөрдөгч нар албан томилолтоор явж ажиллах төлөвлөгөөг батлуулахад нь аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, шугам замын хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, цагдаа нарыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулж хэвшсэн. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн тусгай бүлгээр сэжигтэнг дайчлан баривчуулсан тохиолдол гараагүй байна.

Гэрч хохирогчийн амь бие нэр төрд, алдар хүндэд халдаж аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай тохиолдол бүртгэгдээгүй. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд болон хэрэгт чухал ач холбогдол бүхий гэрч нарт хэрэв амь бие, нэр төр, алдар хүндэд халдсан тохиолдолд тухайн хэргийг шалгаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт нэн даруй мэдэгдэх талаар санамж, мэдээлэл өгөх хэвлэмэл 10 хуудсыг гэрчид, 9 хуудсыг хохирогчид өгч ажилласан.

6.3. Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар

Тус газрын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тодотгол хийж байгууллагын эрсдэлд суурилсан төлөвлөгөөг 12 заалттайгаар боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

Тус газрын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тодотгол хийж байгууллагын эрсдэлд суурилан 12 заалттайгаар боловсруулан Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 08 дугаар сарын 01-нээс 03-ны өдрүүдэд Эрдэнэт, Сэлэнгэ, Дархан өртөө, зангилаадад “Шалгалт-1”, Урд чиглэлд 2017 оны 09 дүгээр сарын 07-ноос 10-ны өдрүүдэд Чойр, Олон овоо, Айраг, Сайншанд, Замын үүд өртөө, зангилаадад “Шалгалт-2” нэртэй удирдамж төлөвлөгөөтэй шалгалтыг явуулсан. Шалгалтаар урд бол он хойд чиглэлийн дэд хэсгийн үйл ажиллагаа, 2017 онд цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, газрын төлөвлөгөөний хэрэгжилт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулж байгаа ажлын үр дүн, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээнд иргэд, төмөр замчдын үнэлгээ, ажлын нөхцөл бололцоо ачаалал, ахуй амьдралын түвшинг тогтоох, цаашид авах арга хэмжээний талаар гэсэн үндсэн чиглэлүүдээр явуулсан.

Шалгалтын дүнг ажлын хэсэг ахлагч Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Гүнчин- Иш илтгэх хуудсаар холбогдох материалын хамт зөвлөлийн 18 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга цагдаагийн хошууч Б.Гүнчин-Ишд 7 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн, холбогдох албан тушаалтангуудад хугацаатай үүрэг чиглэл өгч зарим албан тушаалтанд ажлын үр дүнгээр хариуцлага тооцсон.

НХЖХТ-ийн дарга цагдаагийн хошууч Б.Гүнчин-иш, Хэв журмын ахлах байцаагч цагдаагийн хошууч Ө.Баярмаа нар Албадан эрүүлжүүлэх байрны алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, хөтлөгдвөл зохих бүртгэл судалгаа, эм тарианы жагсаалтын дагуу бүртгэл тооллого явуулж Улаанбаатар төмөр замын нэгдсэн эмнэлгийн Сургалтын албатай хамтран 4 бага эмчээс "Бага эмчийн мэдвэл зохих" мэргэжлийн 30 асуулт бүхий тестээр шалгалт авч дүнг гарган, сувилахуйн менежер Б.Мөнхмэнд "Бага эмчийн ур чадварыг дээшлүүлэх" сэдвээр 1 цагийн сургалтыг зохион байгуулж хангалтгүй үнэлгээ авсан бага эмч цагдаагийн дэслэгч Цэндхүү, ахлах дэслэгч Оюунжаргал нарт өөрийгөө хөгжүүлж боловсрох хугацаатай үүрэг өгч дахин шалгалт авахаар шийдвэрлэсэн.

Газрын төв байрны аюулгүй байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлын түвшин өртөө, зөрлөгт ямар байгааг газар дээр нь шалган тогтоон авах арга хэмжээг удирдлагад танилцуулах зорилгоор аж ахуйн ажилтан, цагдаагийн ахмад Г.Гомбосүрэн, дэд хэсэг хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Л.Эрдэмбилэг нар хамтран 2017 оны 09 дүгээр сарын 20-ноос 24-ний өдрүүдэд хойд чиглэлд Мандал, Түнх, Зүүнхараа, Баруунхараа, Салхит, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ зэрэг өртөө зангилаадын байрлах алба хаагчдын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, үндсэн эд хөрөнгийг тоолж, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж шаардлага хангахгүй байгаа эд хөрөнгийн жагсаалт, хэрэгцээ шаардлагатай байгаа эд хөрөнгийн судалгааг гаргаж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хууль зүйн сайдын А/238 дугаар тушаалаар батлагдсан "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтын зохион байгуулах журам"-д заасны дагуу албаны шалгалт явуулах, албаны шалгалт явуулахдаа хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, алба хаагчдад хүндэтгэлтэй хандах, зарчимч байдлыг баримтлан албаны шалгалтыг бүрэн гүйцэд хийж, алба хаагчийн гэм буруу, учруулсан хохирол, түүний хэр хэмжээг бүрэн тогтоож баримт материалыг гүйцэд бүрдүүлэн, албаны шалгалтыг цагдаагийн газрын даргын шийдвэртэй маягтыг хүлээн авснаар хүний нөөцийн мэргэжилтнээс нэгдсэн дугаарыг авч, зөрчлийн шинж байдал, шалтгаан нөхцөл, зөрчил гаргагчийн хувийн байдлыг тогтоож дүгнэлт гаргаж байна.

Албаны шалгалт явуулах тухай бүрд ажлын төлөвлөгөө боловсруулж байгууллагын даргаар батлуулан зөрчил гаргасан алба хаагчийг албаны шалгалтын материалтай танилцуулж энэ тухай тэмдэглэл хөтөлж, шалгалтын дүнг хэлэлцэхэд боломжит бүх тохиолдолд түүнийг байлцуулж, эрхээ хамгаалах боломжийг олгон, шалгалтыг тогтоосон хугацаанд хийж, дүнг илтгэх хуудсаар дэлгэрэнгүй бичиж, авах арга хэмжээний саналыг тодорхой, үндэслэлтэй тодорхойлон газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж байна.

Тус цагдаагийн газарт 2017 оны 03 дугаар улиралд 6 албаны шалгалт хийгдсэн ба 3 албаны шалгалтаар алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэн ажил тасалсан цагдаагийн ахлах ахлагч Б.Чулуунхүү, согтууруулах ундааны зүйл хэрэглэн цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүйг зөрчсөн цагдаа, цагдаагийн дэд ахлагч М.Энхсайхан нарт албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах, албаны А серийн үнэмлэх үрэгдүүлсэн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Д.Лхагвацэндэд сануулах сахилгын шийтгэл оногдуулан ажилласан байна.

Долоо: Дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл:

1. Газар нь ЦЕГ-аас 2017 онд дэвшүүлсэн зорилт, зорилтын шалгуур үзүүлэлтийн тогтоосон үзүүлэлт, цагдаагийн төв байгууллагын даргатай байгуулсан менежерийн

гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ ханган биелүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлэх.

2. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэ тутам батлагдсан хуулиудыг үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй нэг мөр хэрэгжүүлэхэд удирдлагын зүгээс тогтмол анхаарал хандуулан сургалт, практикийг хослуулан хууль хяналтын бусад байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулан харилцан мэдээлэл солилцон хамтран ажиллахад анхаарах.

3. Сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр:

Сахилга ёс зүйн зөвлөлийг сар бүр хуралдуулан тухайн сард гарсан зөрчлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, үйлдэгдсэн сахилгын зөрчил нэг бүрийн шалтгаан нөхцөлийг бодитой эсэхийг тогтоон урьдчилан сэргийлж ажиллах, Сахилгын зөвлөгөөнийг алба хаагч нарын идэвхийг сэргээх зорилгоор шинэлэг хэлбэрээр зохион байгуулж гаргасан санал зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг гарган дараа улирлын сахилгын зөвлөгөөнөөр үр дүнг тайлагнаж байх. 5-аас доошгүй жил ажиллахдаа хамт олны дунд бусадтай сайн үлгэр дуурайлтай сахилга, ёс зүйн зөрчил дутагдал заагдаж байгаагүй хамт олноо манлайлан ажиллаж байгаа алба хаагч нарт батламж гардуулах. Зөрчил гаргасан алба хаагч нартай сэтгэл зүйн хувийн хэрэг нээн шалтгаан нөхцөлийг тогтоон хувь хүнтэй тулж ажиллах, ажлын идэвх урмыг сэргээн ар гэрийн холбоог сайжруулж, хяналтыг тогтмолжуулах талаар ажил арга хэмжээ зохион байгуулах.

4. Сургалт, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:

Цагдаагийн байгууллагаас Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, 2017 оны албаны сургалтын төлөвлөгөөнд заагдсан 14 төрлийн сургалтуудыг зохион байгуулах, их дээд сургууль төгссөн ахлагч бүрэлдэхүүнээр мэдээллийн өдрүүдэд мэдээлэл хийлгэх, мөн газрын алба хаагчдын дунд сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, сэтгэхүйг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрын хүмүүжил олгоход чиглэгдсэн “Хөл бөмбөг”, “Дартас”, Танин мэдэхүй “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулах “Бүх цэргийн музейг” алба хаагчдад үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

5. Гэмт хэрэг зөрчлийн өсөлт бууралт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр:

Мэдээлэл судалгааны ахлах байцаагчийн гаргасан гэмт хэрэг, зөрчлийн судалгаанд суурилан дүгнэлт хийж эргүүлийн чиглэл, хийх арга хэмжээг оновчтой зохион байгуулах.

Төмөр замын аюултай бүс болон бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг, богино хэмжээний шторкийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллах.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиолгох талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад бичиж байгаа албан мэдэгдлийн чанарыг сайжруулах, мэдэгдлийн мөрөөр гүйцэтгэсэн ажлыг газар дээр шалгах, тодорхой хариуцлага тооцоход тус албадын дарга нараас тавих хяналтыг сайжруулах.

6. Дотоод хяналт шалгалтын чиглэлээр :

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажлын цаг ашиглалт, дүрэмт хувцас, агсамж тусгай хэрэгслийг ЦБҮАЖ-

ын дагуу өмсөж хэрэглэж байгаа болон ажлын үүрэг гүйцэтгэлтэд нь хяналт, шалгалт хийж шалган зааварчилах.

ОНБК болон УБЗҮТБ-ын жижүүр, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа томилгоот алба хаагчдын үйл ажиллагаанд шалгалт явуулж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, шаардлагатай тохиолдолд зөрчил заагдсан алба хаагчдыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар оруулж ажлын хариуцлага тооцох.

Замын цагдаагийн хэсгийн зохицуулагч цагдаа нарын ажлын цаг ашиглалт, дүрэмт хувцас, агсамж, тусгай хэрэгслийг ЦБҮАЖ-д заасны дагуу хэрэглэж замын хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт хийх үедээ иргэдтэй цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандартын дагуу харьцаж, байгаа эсэх. Бэлэн бус торгуулийн багаж болон бусад техник хэрэгслийг зааврын дагуу ашиглаж зөрчил гаргасан жолооч нарт арга хэмжээ тооцохдоо холбогдох хууль дүрмийг оновчтой зөв хэрэглэж байгааг шалган зааварчлах.

Цагдаагийн газрын зэвсэг агуулах өрөөнд нэвтрэх, зэвсэг хэрэглэлд үзлэг хийх журам, Гамшиг ослын нөхцөл, байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө, Галт зэвсгийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийн жагсаалтыг гаргаж, Зэвсэг, галт хэрэглэлийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бүртгэл, тооцоог томилогдсон комиссийн бүрэлдэхүүн нь нэгдсэн тооллого явуулсан эсэхийг шалган зааварчилж, үнэлэлт дүгнэлт өгөх.

7. Архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөж байгаа баримт бичгийн эмх цэгц хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгаж, дутагдал зөрчлийг арилгах.

Архив албан хэрэг хөтлөлтийн асуудлаар цагдаагийн төв байгууллага, архивын газраас ирүүлсэн ажлын чиглэл, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллах.

Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан түүх эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй болсон архивын баримтын устгах хэргийн актыг боловсруулан ББНШКомиссын хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэл, устгах хэргийн акт, саналын хамт Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хуралд танилцуулж шийдвэрлүүлэх.

Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газраас ирүүлсэн үүрэг, чиглэл хуваарийн дагуу байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан байнга хадгалах хадгаламжийн нэгжийг Төв архивын газарт нөхөн бүрдүүлэлтээр шилжүүлэх.

8. Алба хаагчдын эрүүл мэнд нийгмийн асуудлын чиглэлээр:

Ажиллагсдыг эрүүл, зохистой хооллох, биеийн жингийн индекс, бэлхүүсний тойргоо хянаж хэвийн хэмжээнд барих, идэвхтэй хөдөлгөөн хийх боломжоор хангах, халдварт бус өвчний эрт илрүүлэлтэд хамруулах, архи, тамхигүй орчин бүрдүүлэх асуудлыг байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журамдаа тусгах, эрүүл хүнийг дэмжин урамшуулах (цалингийн нэмэгдэл, ажлын нэг өдрөөр чөлөө олгох гэх мэт) хөшүүрэг бий болгон ажиллах.

Анхан шатны нэгжид буюу орон нутагт ажиллаж буй цагдаагийн алба хаагчдыг орон байр, хүнс тээвэр, холбооны хэрэгслээр хангах, түүний гэр бүлийн гишүүдийн ажлын байр болон бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр төмөр замын байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх.

Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажлын байрны осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл сургалт зохион байгуулах.

Тус цагдаагийн газраас 4 дүгээр улиралд дээрх ажил арга хэмжээнүүдийг зохион байгууллахаар төлөвлөн ажиллаж байна.

ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР